



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/813

Ховд

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтуудыг үндэслэн Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2008 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 124 дүгээр захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Цамбагарав багийн 7-5 тоот, 525,0 м2 хэмжээтэй, 2625000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Б.Чулуунцэцэгт, аймгийн Засаг даргын 2005 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 128 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Буянт баг Олзвойн 1-9 тоот, 608,0м2 хэмжээтэй, 1520000 үнэ бүхий газрыг иргэн Ц.Дагданготовд тус тус үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2.Дээрх нэр бүхий иргэдэд шилжүүлсэн газарт хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга /Э.Дөлбадрал/, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /С.Хоролсүрэн/ нарт үүрэг болгосугай.


3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 124 дүгээр захирамжийн 20 дахь заалтын Г.Нямхуяг, Н.Ариунболор, Н.Ариунчимэг, Н.Ариунболд нарт холбогдох хэсгийг, аймгийн Засаг даргын 2005 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 128 дугаар захирамжийн 416-419 дэх заалтын Н.Уранчимэг, Д.Энхбаяр, Д.Энх-Оргил, Д.Батболд нарт холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/813 Ch.
02 4133

Аймгийн Засаг даргын 2020 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн А/813 дугаар
захирамжийн хавсралт



ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

Овог нэр	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар өмчилж авсан захирамжийн огноо	Дугаар	Хавсралтанд орсон дугаар
Г.Нямхуяг Н.Ариунболор Н.Ариунчимэг Н.Ариунболд	Цамбагарав баг 7-5 тоот	525,0	2008-04-29	124	20
Н.Уранчимэг Д.Энхбаяр Д.Энх-Оргил Д.Батболд	Буянт баг Олзвойн 1-9 тоот	608,0	2005-05-25	128	416-419